



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/232

Улаанбаатар хот


Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 4 дүгээр зүйлийн 4.6.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 02-02/3331 тоот албан бичгээр ирүүлсэн Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө, 111 тоотод байрлах МЦ ХХК-ний "Хаанчлал" баарны спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналын дагуу тус баарны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн шийдвэрийг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Татварын газарт хүргүүлэхийг Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хэлтэс /Б.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/, Баянзүрх дүүргийн Засаг дарга /Т.Баясах/-д тус тус даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  С.ГАНТӨМӨР



1110300674